

**“ИРГЭНИЙ ЁС ЗҮЙН БОЛОВСРОЛ” СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР,
СУРАХ БИЧГИЙН АГУУЛГА**

*О.Пүрэв (Sc.D)
Л.Цэдэнсодном (магистр)
Боловсролын хүрээлэн*

Түлхүүр үгс: ёс суртахуун, үнэт зүйл, ёс зүйн боловсрол

Товч утга: Дэлхийн зүрхэн газар орших Монгол улс өв соёл, түүх, шүтлэг бишрэлийн баялаг уламжлалтай билээ. Өдгөө Монгол улс ардчилсан нийгмийн улс төр, эдийн засаг, оюун санааны эрх, эрх чөлөөг бүрэн дүүрэн эдэлж байгаа ч хүүхэд, залуучууд, иргэдийн нь хүмүүжил, ёс суртахуун сайнгүй байгаа нь олон жишээ, баримтаас харагддаг. Тухайлбал, ” улсын хэмжээнд 2019 оны эхний 4 сарын байдлаар гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн 62 буюу 22.5 хувь нь эмэгтэй, согтуугаар гэмт хэрэгт холбогдсон 5, бүлэглэн үйлдсэн гэмт хэрэгт холбогдсон 47 хүүхэд байна” (“Хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа, анхаарах асуудал” илтгэл 2019.05.29.) гэж мэдээлсэн нь хүүхдийн хүмүүжил, төлөвшлийн асуудалд онцгойлон анхаарах шаардлагатайг харуулж байна.

Ийм учраас Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/390 дүгээр тушаалаар “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөр батлагдаж, ерөнхий боловсролын нийт сургуулийн 1-12-р ангийн бүх сурагч уг хичээлийг долоо хоногт 2 цагаар, 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн, албан ёсоор судалж буй нь тэдний хүмүүжил, ёс суртахууны төлөвшилд ихээхэн ач тустай байна.

“Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөрийн цөм нь сурагчийн хөгжил, төлөвшил, агуулгын мөн чанар нь монгол өв соёл юм. Монгол өв соёл бол ёс зүйг чухалчилдаг бөгөөд “хүнийг ёс суртахуунаар нь тодорхойлдог. Монгол хүний үнэт зүйл ёс суртахуунд нь оршдог. Ёс зүйн боловсролыг эзэмших арга ухаантай сурагч бол нэг талаас ёс зүйтэй, нөгөө талаас ёс суртахуунтай иргэн болдог. “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөр хэрэгжсэнээр сурагчид ёс зүйн боловсрол эзэмших арга ухаантай, ёс суртахуунтай иргэн болж хүмүүжиж, төлөвшинө. Сурагчид ёс зүйн боловсрол эзэмших нь зөвхөн уг сургалтын хөтөлбөрөөр хязгаарлагдахгүй, монгол хэл, бичиг, уран зохиол, түүх, нийгмийн ухаан зэрэг бусад сургалтын хөтөлбөртэй нягт холбоотойгоор хэрэгжинэ.

“Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөр нь нийтлэг үндэслэл, зарчим, зорилго, зорилт, агуулга, арга зүй, үнэлгээ, хэрэглэгдэхүүн, бусдад түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа гэсэн бүтэцтэй. Сургалтын хөтөлбөрийг бага ангийн сурагч монгол хүн болж төлөвших суурь мэдлэг, чадвар, дадал эзэмших; дунд ангийн сурагч монгол иргэн болж хүмүүжих; ахлах ангийн сурагч дэлхийд байр сууриа эзлэх суурь мэдлэг, чадвар, дадал эзэмших зарчмыг баримтлан боловсруулсан. (*“Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөр, түүний удирдамж. 12 дахь тал*)

“Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөрийн агуулга нь анги ахих тусам өргөжин гүнзгийрэх агуулга бүхий Өөрийгөө таньж, хөгжүүлэе; Бусдыг хүндэлж, баярлуулъя; Уламжлалт өв соёлоосоо суралцъя; гэсэн бүлгүүдээс бүтнэ.

Сургалтын хөтөлбөрийн дагуу 1-5-р ангийн “Монгол ёс, хүмүүжил” сурах бичгүүдийг зохион хэвлэж, сургалтад хэрэглэж байна. Мөн “Монгол ёс, хүмүүжил” хичээлийн багшийн номууд бэлтгэгдэж байна. “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтыг хэрэгжүүлэх хүний нөөц, орчин, хэрэглэгдэхүүнийг бэлтгэх, бүрдүүлэх болон энэхүү сургалт, боловсролын үзэл санаа, үнэ цэнийг бүх сургууль, эцэг эх, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа амжилттай өрнөж байна.

* * * * *

1. Үндэслэл

Дэлхийн зүрхэн газар орших Монгол улс өв соёл, түүх, шүтлэг бишрэлийн баялаг уламжлалтай билээ. Өдгөө Монгол улс ардчилсан нийгмийн улс төр, эдийн засаг, оюун санааны эрх, эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлэж байгаа ч хүүхэд, залуучууд, иргэдийн нь хүмүүжил, ёс суртахуун сайнгүй байгаа нь олон жишээ, баримтаас харагддаг. Тухайлбал, “улсын хэмжээнд 2019 оны эхний 4 сарын байдлаар гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн 62 буюу 22.5 хувь нь эмэгтэй, согтуугаар гэмт хэрэгт холбогдсон 5, бүлэглэн үйлдсэн гэмт хэрэгт холбогдсон 47 хүүхэд байна” (“Хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа, анхаарах асуудал” илтгэл 2019.05.29.) гэж мэдээлсэн нь хүүхдийн хүмүүжил, төлөвшлийн асуудалд онцгойлон анхаарах шаардлагатайг харуулж байна.

Онол, үзэл баримтлалын хувьд: “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөрийг Монгол өв соёл, зан заншилдаа тулгуурласан, онол, үзэл баримтлалаар боловсруулж, ёс суртахууныг чухалчилж, амьдрал, зан үйлдээ дадал хэвшил болгосон “хүн”-ийг төлөвшүүлэхэд зорьсон байна. Ёс зүйн боловсролыг эзэмших арга ухаантай сурагч бол нэг талаас ёс зүйтэй, нөгөө талаас ёс суртахуунтай иргэн болдог. Сурагчдын судлах, хэвшил болгох ёс зүй нь хүн ямар байх ёстойг онолын хувьд тодорхойлбол, ёс суртахуун нь сурагчдад төлөвших хэм хэмжээ, зан үйл бөгөөд амьдралын бодит асуудлыг ёс суртахууны үүднээс шийдвэрлэх, тухайлбал, биеэ хэрхэн авч явах, бусадтай хэрхэн харилцах, мөн хүний зөв, буруу болон сайн, муу үйл гэж юу болох; уужуу тайван, даруу төлөв, нийтэч, хүнлэг энэрэнгүй, ажилч хичээнгүй, биеэ даасан, зүтгэл, чармайлт, тууштай байх, тэсвэр тэвчээр, эв эе, эх оронч үзэл; зэрэг хүний зан чанартай холбоотой хийсвэр, ерөнхий үзэл санаа буюу ёс суртахуун болон өдөр тутмын бодит амьдралыг сурагчид танин мэднэ. Хулгай хийхгүй, худал хэлэхгүй, хорон муу санаа өвөрлөхгүй, ширүүн үг хэлэхгүй, амьтны амь таслахыг тэвчих зэрэг сурагч бүр мөрдвөл зохих дүрэм, горим, үнэлэмж болон муу үйлийг эс үйлдэх зэрэг нийгмийн шинжтэй зан суртахуун нь ёс суртахууны хэм хэмжээ болдгийг сурагчдад төлөвшүүлэхээр үзэл баримтлалдаа тусгасан байна.

Олон улс орны эрдэмтэд монголчуудын өв соёл нь тэдний ёс суртахуун, амьдрал ахуйд нь шингэсэн байдгийг судалж, “Эрийн гурван наадам, цагаан сар гэх мэт үндэсний өв уламжлал шингэсэн баяраар монголын бүх иргэн бүгд адил тэгш баярлаж чаддаг гэж тэмдэглээд, хамгийн чухал нь энэхүү баяр ёслолоороо ёс суртахууныг нийтээр эрхэмлэн

дээдэлдэг нь бахархуштай юм”¹ гэжээ. Монгол хүний амьдрал, аж төрөх онцлогтой нягт уялдсан уламжлалт өв соёл, түүн дотроос ёс суртахууны эрхэм нандин өв соёлоор хүүхэд багачуудаа хүмүүжүүлж, төлөвшүүлэх нь “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалын нэн үнэт чанар юм.

Ийм учраас Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/390 дүгээр тушаалаар “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөр батлагдаж, ерөнхий боловсролын нийт сургуулийн 1-12-р ангийн бүх сурагч уг хичээлийг долоо хоногт 2 цагаар, 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн, албан ёсоор судалж буй нь тэдний хүмүүжил, ёс суртахууны төлөвшил, хөгжилд ихээхэн ач тустай байна.

”Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөр нь нийтлэг үндэслэл, зарчим, зорилго, зорилт, агуулга, арга зүй, үнэлгээ, хэрэглэгдэхүүн, бусдад түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа гэсэн бүтэцтэй.

2. Сургалтын хөтөлбөрийн зарчим, зорилго, зорилт

Зарчим: Сургалтын хөтөлбөрийг бага ангийн сурагч монгол хүн болж төлөвших суурь мэдлэг, чадвар, дадал эзэмших; дунд ангийн сурагч монгол иргэн болж хүмүүжих; ахлах ангийн сурагч эх орныхоо эзэн монгол хүн болж төлөвших зарчим (*“Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөр, түүний удирдамж. УБ.,2019. 12 дахь тал*) баримтлан, сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилтыг тодорхойлж, агуулга, арга зүй, үнэлгээг боловсруулсан байна. Үүнд:

- Монголын уламжлалт өв соёлын мөн чанарыг танин мэдэж, түүнээс суралцах, амьдралдаа хэрэгжүүлэхэд хөтлөх
- Монгол хүний амьдралын бодит байдлыг судлах
- Агуулга нь ёс зүй, ёс суртахууны талаарх ухагдахуун, ойлголтоос бүрдэх төдий биш, ёс зүйн боловсрол эзэмших арга ухааныг өөрөө бүтээхэд чиглэх
- Сурагчийн нас, сэтгэцийн онцлог, эрэлт хэрэгцээнд нийцсэн байх
- Ихийг гүехэн биш, багыг гүнзгий судлах
- Анги ахих тусам өргөжин гүнзгийрэх
- Залгамж холбоог сайтар хангах зэрэг болно.

Сургалтын хөтөлбөрийн зорилго нь: сургалтыг хүнлэг энэрэнгүй, цэвэр ариун сэтгэлтэй, билиг оюун төгөлдөр, уламжлалт ёс заншил, ахуйгаа таньж мэдсэн, хүндэлж хамгаалдаг, монгол үндэстнийхээ хэл, соёл, ёс заншлыг эзэмшсэн, бахархаж хэрэглэдэг, бие, хэл, сэтгэлээрээ сайн үйл хийдэг, эх орон, улс үндэстнээ эрхэмлэн дээдлэх үүрэг, хариуцлагаа ухамсарласан, хүмүүнлэг нийгмийг цогцлоон байгуулах ирээдүйн монгол иргэнийг өсгөх, хүмүүжүүлэх, бэлтгэхэд оршино.

Сургалтын хөтөлбөрийн зорилт:

-Сурагч ёс зүйн хэм хэмжээг танин мэдэж, ёс суртахууныг эзэмших

-Уламжлалт сурган хүмүүжүүлэх ухааны арга, аргачлалын учир утгыг танин мэдэж, сурч, судлах үйлдээ мөрдөх

-Өөрийн гэсэн зөв үзэл бодолтой болж, түүндээ тууштай байж, үзэл бодлоо баталж, нотолж чаддаг байх

-Бие, хэл, сэтгэлээр үйлдэх сайн үйлийг зуршил болгож, муу үйлийг цээрлэн жигших

¹ Нэгдсэн Үндэстний байгууллагын, Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага

-Хүмүүнлэг нийгмийг бүтээн байгуулахыг эрмэлзэх, хүн, нийгэм, байгаль орчинтой зөв харилцах, нийгмийн үйл хэрэгт ухаалгаар, идвэхтэй оролцох

-Бусад хүнийг болон төр улс, эх орон, хүн төрөлхтнийг хүндлэхийн учир утгыг ойлгож, ухааран хүндлэх

-Амьдралын зорилгоо зөв тодорхойлж, түүнд зөв аргаар хүрэх, бие даан амьдрах арга ухаанд суралцах

-Сурч судлах, хөдөлмөрлөх, бүтээх үйлд шамдах, чин сэтгэлээсээ хандах

-Гэр бүл, анги хамт олон, бусад хүний болон нийгмийн өмнө хүлээх үүрэг, хариуцлагаа сайтар ухамсарлах

-Асуудлыг ёс суртахууны хувьд зөв, оновчтой шийдвэрлэх, бэрхшээлийг даван туулах хамсарлаж, зорилго нэгтэй, эв эетэй байж, нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулах, улмаар дэлхийд байр сууриа эзлэх иргэн болж хүмүүжих

-Айх, ичих ухамсартай, ичгүүр сонжууртай байж

-Санаа бодлоо нээлттэй илэрхийлж, бусдын үзэл бодолд хүндэтгэлтэй хандах

-Хойч үеийнхээ өмнө хүлээх үүрэг, хариуцлагаа гүн у, тогтсон хэв ёс, зан заншил, төрийн хууль, дэг журмыг баримталдаг иргэн болж төлөвших

3. Сургалтын хөтөлбөрийн агуулга

Бага, суурь, бүрэн дунд боловсролын агуулга нь өргөжил, гүнзгийрлийн хувьд ялгаа бүхий дараах нийтлэг бүтэцтэй. Үүнд:

- Өөрийгөө таньж, хөгжүүлэе
- Бусдыг хүндэлж, баярлуулъя
- Уламжлалт өв соёлоосоо суралцъя

“Өөрийгөө таньж, хөгжүүлэе” бүлэг буюу айн агуулга нь өөрийн алдаа гэмээ сэтгэлээсээ эхэлж таньж засах, өөрт байгаа болон ирээдүйд бий болох сайн зан чанараа танин мэдэж, улам бүр хөгжүүлэхэд чиглэнэ.

“Бусдыг хүндэлж, баярлуулъя” бүлэг буюу айн агуулгаар нэн тэргүүнд өөрийгөө таньж, хөгжүүлэхийн зэрэгцээ бусдыг хүндэлж, баярлуулж байж, хүндлэл, баяр баясгаланг бусдаас хүртэх боломжийг бүрдүүлнэ. Мөн эцэг эх, багш, асран хамгаалагч, төрөл садан, нутаг усныхан, өөрөөс ахмад хүнийг хүндлэх, бусад хүнийг ойлгох, бусадтай зөв харилцах чадвар эзэмших агуулгатай. Тухайлбал, сэтгэл хөдлөлөө зөв залах, удирдах, зөв илэрхийлэх, бусдаас суралцах, бусдад талархах, бусад хүнийг уучлах, бусдын ажил хөдөлмөрийг хүндэтгэх, ажил хөдөлмөрийг чин сэтгэлээсээ, үр бүтээлтэй хийх, нийгэмд хамтдаа амьдрахад шаардлагатай зан үйлийг баримтлах талаар судална.

“Уламжлалт өв соёлоосоо суралцъя” бүлэг буюу айн агуулга нь монголчуудын хүн төрөлхтнөөс ялгарах онцлог болох үндэсний уламжлалт ёс, зан заншлыг мэдэж, улмаар нандигнах, өвлүүлэн хөгжүүлэх нь хувь хүн, айл гэр, анги хамт олон, сургууль, нутаг усныхан хийгээд монгол үндэстний дархлааг улам бүр бататгахад чиглэсэн мөн чанартай.

Тус бүлэг буюу ай нь монголын уламжлалт нүүдлийн сонгодог мал аж ахуйн болон баяр наадмын зан үйлийг мэдэж, мал аж ахуйн хөдөлмөр, аж төрөх ёсонд суралцах, удам судраа мэдэх, Монгол наадам, цагаан сар зэрэг баяр ёслолыг ёсчлон тэмдэглэх, гэр бүлийн уламжлалт харилцаанаас суралцах, монголчуудын соёлын биет болон биет бус өвөөс судлан суралцах, үйлийн үр, асрах, энэрэх сэтгэл, арга, билгийн шүтэн барилдлага, зөв сэтгэлийг бясалгаж, дадуулах зэрэг монгол хүний зайлшгүй танин мэдэж, гэгээрч,

ажил амьдралдаа дадал хэвшил болгон мөрдөж эрхэмлэн хэрэглэвэл зохих агуулгаас бүрдэнэ.

4. Сургалтын хөтөлбөрийн арга зүй, хэрэглэгдэхүүн

- Ёс зүйн ойлголт, ухагдахууныг тоочин заах, номлон сургах биш, сурагч ёс суртахууны боловсрол эзэмших арга ухаанд өөрийгөө дайчлан суралцах, ёс суртахууны мэдлэг, чадварыг өөрөө болон хамтран бүтээх, улмаар дадуулан хэвшүүлэх, итгэл үнэмшил болгох таатай нөхцөл, боломжийг нь бүрдүүлж өгөх
- Ёс зүй, ёс суртахууны боловсрол эзэмших арга ухааныг өөрөө бүтээнэ хэмээн сурагчдаа зөнд нь орхилгүй, суралцах үйлийг нь сэдэлжүүлэх, залах, зөвлөх, дэмжих, туслах
- Сурагчдад өөрийн болон бусдын алдаанаас суралцах, бусадтай хамтарч ажиллангаа суралцах, сурч мэдсэнээ хамтдаа хэрэгжүүлэх боломж олгох
- Сурагчийн хөгжил, төлөвшлийн онцлогоос үүдсэн ялгаатай байдлыг үгүйсгэх биш, түүнийг дэмжсэн, түүнд нийцсэн арга ашиглаж, тэгш, тэнцүү байдлыг нь хангах

Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сурагчдад ёс суртахууны цогц мэдлэг, чадвар олгох, мэдлэгийг хэрэглэх чадвар, дадал төлөвшүүлэх нь эл хичээлийн өвөрмөц онцлог болон арга зүйн шийдэлтэй нь шууд холбоотой. “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх хичээлүүд нь ихээхэн онцлогтой бөгөөд сурагчдад XXI зууны хамгийн чухал чадвар болох хандлага буюу сэтгэлийн хүмүүжлийг төлөвшүүлэх, хандлагаар дамжуулан ёс суртахуунтай, хүнлэг, энэрэнгүй, эх орноо эрхэмлэн дээдэлдэг иргэн болгон хүмүүжүүлэх нь энэхүү хичээлийн үнэт нандин үүрэг юм. Тэгэхээр тухайн хичээлийг зааж байгаа багшийн хувьд хичээлийн онцлог, давуу тал, үнэ цэнэ, нарийн төвөгтэй байдлыг өөрөө сайтар ухамсарлаж, нэгж болон ээлжит хичээл бүрээр сурагчдад ёс суртахууны ахиц гаргахуйцаар хичээлийн арга зүйг боловсруулан сургалтын үйл ажиллагааг явуулах нь ирээдүйн ёс суртахуунлаг иргэнийг төлөвшүүлэх багшийн эрхэм чухал үүрэг, хариуцлага билээ.

Иргэний ёс зүйн боловсролын сургалтын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх чухал нөхцөл, хүчин зүйлийн нэг нь сурах бичиг, хэвлэмэл болон цахим бусад хэрэглэгдэхүүн, сургууль, орон нутгийн дотоод, гадаад таатай орчин юм. БСШУСЯ-наас ЕБС-ийн 1-12-р ангид судлах Иргэний ёс зүйн боловсролын бүх сурах бичиг, багшийн ном, зөвлөмж, цахим хэрэглэгдэхүүн, унших бичгийг дэс дараатай зохион хэвлүүлэх, түгээх ажлыг тодорхой бодлого, стратегийн хүрээнд хэрэгжүүлж байна. Тухайлбал, Сургалтын хөтөлбөрийн дагуу 1-5-р ангийн “Монгол ёс, хүмүүжил” сурах бичиг бүрийг болон багшийн нэгдмэл номыг 2019 онд зохион хэвлэж, сургалтанд хэрэглүүлэв.

Түүнчлэн суурь, бүрэн дунд боловсролын буюу 6-12-р анги тус бүрийн сурах бичгийг зохиолгож, 2020 онд хэвлүүлж, сургуулийн практикт хэрэглүүлсэн нь ихээхэн амжилт юм. ЕБС-ийн 6-12-р ангийн Иргэний ёс зүйн боловсролын багшийн номууд ч зохиогдсон болно. Мөн өдгөө Иргэний ёс зүйн боловсролоор сурагчдын ойлгож унших, сонсох, үйлдэн хэвших, бүтээхүйг дэмжсэн сургалтын хэрэглэгдэхүүнүүдийг судлан боловсруулах ажил Боловсролын хүрээлэнд амжилттай хийгдэж байна.

5. Сургалтын хөтөлбөрийн үнэлгээ:

Аливаа сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн эцсийн, бодит үр дүн нь үнэлгээ юм. Иргэний ёс зүйн боловсрол хичээлийн үнэлгээнд бусад судлагдахуунаас илүүтэйгээр анхааралтай хандах ёстой. Учир нь сурагчийн ухамсар, сэтгэл дэх ёс суртахуун, зан үйлийн үйл явц, үзэгдлийг үнэлэх, дүгнэх тодорхой хэмжүүр болон арга, аргачлал

одоогоор боловсрол судлал, сурган хүмүүжүүлэх ухаанд цэгцтэй бөгөөд нэг мөр болоогүй байна.

Иймд тухайн сурагчийг яаран үнэлж дүгнэх шаардлагагүй бөгөөд үнэлгээг тодорхой ажиглалт, судалгаанд тулгуурлаж байж тухайн сурагчийн өөрчлөлт, ахицыг өсөн дэвших, өөрчлөгдөх боломжтойгоор уян хатан, алсын хараатай үнэлэх нь сурагчийн сэтгэл ханамжид ч, багшийн дараа дараагийн хичээл, сургалтаа явуулах таатай уур амьсгалд ч эерэгээр нөлөөлөх юм. Үнэлгээний төрөл хэлбэрээс дурдвал:

Оношлох үнэлгээ:

Оношлох үнэлгээг хичээлийн жилийн эхэнд анги удирдсан багш, сургалт явуулж буй багш хамтарч хийнэ. Бага ангид багшийн болон эцэг эхийн оношилгооны үр дүнгээр, дунд, ахлах ангид өөрийн оношилгоо болон оношилгоонд оролцогчдын оношилгооны үр дүнгээр тус тус үнэлнэ.

Явцын үнэлгээ:

- Бага ангийн явцын үр дүнгийн үнэлгээнд сурагчийн өөрийн үнэлгээ 10%, эцэг, эхийн үнэлгээ 30%, анги хамт олны үнэлгээ 20%, багшийн үнэлгээ 40%-ийг тус тус эзэлнэ.
- Дунд, ахлах ангийн явцын үр дүнгийн үнэлгээнд сурагчийн өөрийн үнэлгээ 20%, эцэг, эхийн үнэлгээ 20%, анги хамт олны үнэлгээ 20%, багшийн үнэлгээ 40%-ийг тус тус эзэлнэ.

Жилийн буюу үр дүнгийн үнэлгээ:

Жилийн үнэлгээг IV улирал дүүрэхэд хийнэ. 1,2-р ангийн үнэлгээг анги удирдсан багш нэгтгэж, хувийн хэргийн “Сурагчийн хөгжил, төлөвшлийн тодорхойлолт”-ын төлөвшил, анхаарах зүйл хэсэгт тэмдэглэнэ. 3-12-р ангийн жилийн үнэлгээг хичээл, сургалт явуулж буй багш хийж, хувийн хэргийн Үнэлгээ хэсэгт тус тус тэмдэглэнэ.

Сайн үйлсийн үнэлгээ:

Сайн үйлсийн үнэлгээ гэдэг нь сурагчийн хүмүүнлэгийн чиглэлээр санаачилгаараа хийсэн үйлийн үнэлгээг хэлнэ. Тус үнэлгээг хичээл, сургалт явуулж буй багш хичээлийн жилийн турш дараах шалгуураар үнэлж, хувийн тэмдэглэл хөтөлнө.

- Анги хамт олноо зөв дадал хэвшилд суралцахыг уриалсан ажлыг санаачлан зохион байгуулсан
- Гэр бүл, анги хамт олон, сургуульдаа ёс суртахуунаар зөв үлгэр дуурайл үзүүлсэн
- Талархлын тэмдэглэл /хэн нэгэнд чин сэтгэлээсээ баярлуулсанд, тусалсанд ... нь талархсан сэтгэгдэл/
- Хүмүүнлэг, энэрэнгүй үйл хийсэн
- Бусад

6. “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйлс дэх бүх нийтийн оролцоо

Бусад сургалтын хөтөлбөрийн зорилго, агуулга, арга зүй, үнэлгээ, хэрэглэгдэхүүн, зохион байгуулалт нь уг сургалтын хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсгүүдтэй нягт уялдаа холбоотой байж, сурагчдад ёс суртахууны мэдлэг, чадвар, дадал, итгэл үнэмшил төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх юм. Тийм учраас Иргэний ёс зүйн боловсролын сургалт нь бүх хичээл-судлагдахууны багш нарын хамтын нэгдмэл үйл ажиллагаагаар хэрэгжих билээ. Ялангуяа,

сурагчид ёс суртахууны боловсрол эзэмших нь зөвхөн уг сургалтын хөтөлбөрөөр хязгаарлагдахгүй, түүх, нийгмийн ухаан, монгол хэл, бичиг, уран зохиол зэрэг бусад сургалтын хөтөлбөр хийгээд багш нарын нь мэргэжлийн чадавхи, чин сэтгэл, идвэх, бодит оролцооны үр дүнд хэрэгжинэ.

“Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөр бол цогц хөтөлбөр. Цогц хөтөлбөрийн нэгэн хэсэг нь тус сургалтын хөтөлбөрөөр эцэг эхчүүд хүүхэдтэйгээ адил суралцах явдал нь сургалтын хөтөлбөрийн шинэлэг тал, ач холбогдол юм. Эцэг, эхчүүдийг хүүхдүүдтэй илүү ойртуулах хамтран суралцах, тэдэнд цаг зав гаргах нөхцөл бололцоог үүсгэхийн тулд хичээлийн хөтөлбөрт тусаж орсон дан ганц хүүхдийн ёс зүй, ёс суртахуун, хандлагыг төлөвшүүлэх гэхээсээ илүү бүх нийтийн ёс суртахууны боловсролыг хөгжүүлэх нь чухал билээ.

Сургалтын хөтөлбөрийн агуулгыг сурагчид судалснаар өөрөө өөртэйгөө, ялангуяа сэтгэлтэйгээ ажиллаж, иргэн хүний үндсэн үүргээ сайтар ухамсарлах, бусдын эрх ашгийг хүндэтгэх, ёс зүйн боловсролыг эзэмших арга ухаантай, ёс суртахуунтай иргэн болж хүмүүжиж, төлөвшинө.

ЕБС-ийн сургалт хүмүүжлийн үйлчилгээ бүрийг сурагч ёс зүй, ёс суртахууны боловсрол эзэмших арга ухаанд суралцахад зориулж, тэдний суралцах таатай орчин нөхцөлийг бүрдүүлж, дэмжинэ. Гэр бүл, эцэг эх, асран хамгаалагчид хүүхдээ багаас нь хүмүүжүүлж, сургууль, багш нартай хамтран ажиллах үүрэг хүлээх эрх зүйн орчныг бүрдүүлсэн нь гэр бүл ёс суртахууныг эзэмших, дэлгэрүүлэх анхдагч, үндсэн орчин төдийгүй үнэ цэнтэй сурган хүмүүжүүлэгч байдаг ч, хүүхэд сургуульд элссэн мөчөөс тэрхүү сурган хүмүүжүүлэх үүргийг ерөнхий боловсролын сургууль өвлөн авч, эцэг, эхтэй хамтран ажиллах зайлшгүй хэрэгцээ бий болдог.

Сургууль, багш нар эцэг, эхчүүдэд зориулсан иргэний ёс зүйн боловсрол (хөтөлбөрийн дагуу) эзэмших зорилго, агуулгатай сургалт, зөвлөгөөг сургалтын төлөвлөгөөн дэх “Багш зохицуулах цаг” болон багшийн “Бусад” ажлын цагаар:

- Бага ангид долоо хоног бүр хоёр хүртэлх цагаар
- Дунд, ахлах ангид сар бүр хоёр хүртэлх цагаар зохион байгуулах ажлыг хариуцан гүйцэтгэх юм.

“Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөрийг сургуулийн удирдлага, ажилтан, албан хаагчид, нийт багш, эцэг эхчүүд сайтар судалж, хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

Түүнчлэн “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтыг хэрэгжүүлэх хүний нөөц, орчин, хэрэглэгдэхүүнийг бэлтгэх, бүрдүүлэх болон энэхүү сургалт, боловсролын үзэл санаа, үнэ цэнийг бүх сургууль, эцэг эх, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх цогц үйл ажиллагаа амжилттай өрнөж байна.

Дүгнэлт, санал:

1. “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөрийн үндсэн зорилго нь сурагчийн төлөвшил, хөгжил, агуулгын мөн чанар нь монгол өв соёл, ёс суртахуун юм. Монгол өв соёл бол ёс зүй, ёс суртахууныг чухалчилдаг бөгөөд хүнийг ёс суртахуунаар нь тодорхойлдог. Монгол хүний үнэт зүйл ёс суртахуунд нь оршдог. Ёс зүйн боловсролыг эзэмших арга ухаантай сурагч бол нэг талаас ёс зүйтэй, нөгөө талаас ёс суртахуунтай иргэн болдог. “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөр хэрэгжсэнээр сурагчид ёс

зүйн боловсрол эзэмших өөрийн гэх арга ухаантай, ёс суртахуунтай иргэн болж төлөвшинө, хүмүүжинэ хэмээн үзэж байна.

2. “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтыг амьдралд хэрэгжүүлсэний үр дүнд Монгол улсад амар амгалан, хүмүүнлэг нийгмийг цогцлуулах, боловсролын салбарт ёс суртахуун, хууль зүйн үндсэн үүрэг, зорилгоо амжилттай биелүүлэх, орон нутаг, сургууль, анги хамт олон, гэр бүлд элдэг найрсаг, энэрэлт, асралт уур амьсгал бүрдүүлэх зэрэг олон талын үр өгөөж, ач холбогдол гарах болно.

3. Орчин цагийн Монголын боловсролын түүхэнд анх удаа ерөнхий боловсролын сургуулийн бүх ангийн сурагчид (I-XII ангийн) ёс зүй, ёс суртахууны боловсрол эзэмших сургалтын хөтөлбөрийг судалж эхэлсэн байна.

4. Монголын хүүхэд, залуучуудыг хүмүүжүүлэн, хөгжүүлэхэд бага, суурь, бүрэн дунд боловсролын хүрээнд төдийгүй, дээд болон мэргэжлийн боловсролоор ёс суртахууны зөв хандлага, хүмүүжил олгох нь нэн чухал шаардлагатай байна.

5. Ёс зүй, ёс суртахуун нь Монголын төдийгүй, хүн төрөлхтөний аз жаргал, амар амгалан, нийгмийн эрүүл саруул, тогтвортой хөгжилд тулгуур чухал нөлөөлөл, ач холбогдолтой бөгөөд хүмүүний “сайн, муу болон зөв, буруугийн хэмжүүр, зам мөр”-ийг илэрхийлэн харуулдаг үнэт зүйл мөн. Эдгээрийг хүн судлалын цогц ухаан болох Ёс зүйн шинжлэх ухаан судалдаг байна. Тиймээс бид ёс зүй, ёс суртахуун гэсэн ухагдахууныг хамт хэрэглэв.

6. Дашрамд, Ёс зүй гэдэг нь тухайн шинжлэх ухааны нэршил, харин ёс суртахуун гэдэг нь хүмүүний эзэмших болон судлах зүйл нь бөгөөд, мөн ёс суртахуун нь хүмүүн өдөр тутмын амьдрал, үйл, харилцаа, хандлага, зан үйлдээ баримталдаг зохист зарчим, сэтгэлийн хэм хэмжээнүүдийн цогц тул ёс суртахууны боловсрол хэмээн нэрлэж, хэрэглэж, хэвших нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлж байна.

Талархал: Энэхүү танилцуулга илтгэлийг тухайн үеийн БСШУСЯ-ны шийдвэрээр боловсруулсан “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөр (Бага, суурь, бүрэн дунд боловсрол)-ийн бүтэц, агуулгад үндэслэн бичсэн бөгөөд уг хөтөлбөрийг бичиж, боловсруулсан багийн нийт хамт олонд болон тухайн сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүйн эхийг гаргасан МУ-ын Төрийн соёрхолт, Ардын багш, Доктор Sc.D, Профессор Ш. Чоймаад онцгойлон талархал илэрхийлэх нь зүйтэй гэж үзэж байна.

НОМ ЗҮЙ

1. БСШУС-ын сайдын 2019 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн А/390 дугаар тушаал, Сургалтын хөтөлбөр шинэчлэн батлах тухай
2. Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр УБ.,2019
3. “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөр, удирдамж. Бага боловсрол УБ., 2019.
4. “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөр, удирдамж. Суурь, Бүрэн дунд боловсрол УБ., 2019.
5. “Монгол ёс, хүмүүжил” сурах бичиг I анги. УБ.,2019
6. “Монгол ёс, хүмүүжил” сурах бичиг II анги. УБ.,2019
7. “Монгол ёс, хүмүүжил” сурах бичиг III анги. УБ.,2019
8. “Монгол ёс, хүмүүжил” сурах бичиг IV анги. УБ.,2019

9. “Монгол ёс , хүмүүжил” сурах бичиг V анги. УБ.,2019
10. “Иргэний ёс зүйн боловсрол” сурах бичиг VI анги. УБ., 2020
11. “Иргэний ёс зүйн боловсрол” сурах бичиг VII анги. УБ., 2020
12. “Иргэний ёс зүйн боловсрол” сурах бичиг VIII анги. УБ.,2020
13. “Иргэний ёс зүйн боловсрол” сурах бичиг IX анги. УБ., 2020
14. “Иргэний ёс зүйн боловсрол” сурах бичиг X анги. УБ., 2020
15. “Иргэний ёс зүйн боловсрол” сурах бичиг XI анги. УБ., 2020
16. “Иргэний ёс зүйн боловсрол” сурах бичиг XII анги. УБ., 2020
17. “Монголын уламжлалт ёс зүйн үндэс” О.Пүрэв., Х.Бямбажав. УБ., 2007
18. “Сэтгэлийг ариусгахуй” Ш.Чоймаа., С.Янжинсүрэн. УБ., 2007
19. “Буддын уламжлалт мэдлэг ухааны үндэс”, Г.Лувсанцэрэн, Э.Ариунаа. УБ., 2007

ABSTRACT

Mongolia located at the heart of the world, it has a rich tradition of heritage, history, and beliefs. Nowadays Mongolia has fully enjoyed the freedom of democratic societies in the political, economic, and intellectual levels, but many examples and facts indicate that children, youth and citizens have a lack of discipline, moral and ethical education. For example, “62 children or 22.5 percent of the children involved in crime in the first 4 months of 2019 were girls, from that 5 children were drunk involved in crime, 47 children were committed in gang crime” (“ Report on the issue of concern of Policies and actions aimed at preventing crime against children” , 2019.05.29.) shows that the children’s discipline and ethical education need to be taken into consideration.

Therefore, the “ Education of the Civil Ethics” curriculum is approved by 2019 years’ A\390 statement of the Minister of Education, Culture, Science, and Sports, It states that from 2019-2020 academic year all students of grade 1-12 of the secondary school shall take the formal study of this course 2 hours a week, the subject will affect very beneficial to their discipline and morality.

The core of the “Education of the Civil Ethics” training program is the development, the maturity of the students and nature of the program is the Mongolian heritage. The Mongolian heritage gives more importance on ethics and “people defined by ethics”. The Mongolian values are existing in ethics.

Students who are educated and skilled in earning the methods of civil ethics, they are becoming ethical on the other hand they will be citizens with moral values. The “ Education of the Civil Ethics” program implementation will enable students to develop the wisdom of ethical education and being disciplined and educated citizens with moral principles. The education of civil ethic program is closely related to the other curriculum of the Mongolian language, literature, history, and social sciences.

The “Education of the Civil Ethics” curriculum is structured in the framework of common grounds, principles, goals, objectives, content, methodologies, assessments, tools, and dissemination activities. The curriculum based on the following gradual steps: elementary class

students earn basic knowledge, skills and habits of ethics; intermediary class student to become a Mongolian citizen with code of ethics; senior class students receive the basic knowledge, skills, and habits, which are enable them a world citizen (“Education of the Civil Ethics” curriculum and its guidance, page 12)

The content of the curriculum of “Education of the Civil Ethics” is developing to expanded and deepened year by years; in the first part students realize themselves, develop well-beings, in the second part students will respect and appreciate others; in the third part students learn from the traditional heritages

According to the curriculum program, 1-5th grade textbooks of “The Mongolian ethics and discipline” have been published and used in the primary schools. The Teachers of “The Mongolian Ethics and discipline” have been trained.

The training of human resources, preparing study environment and materials, as well as ideology and value of the ethical education for implementing the teaching of “Education of the Civil Ethical” has been successfully disseminated to all schools, parents and the public.